



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2020 ОНЫ 1 ДҮГЭЭР ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2020 он

АГУУЛГА

1. Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд
2. Дээд байгууллагын тогтоол, шийдвэр, хууль дүрэм журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр
3. Удирдлага, зохион байгуулалт, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр /Улсын бүртгэлийн чиглэлээр/
4. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх талаар
5. Сургалт зохион байгуулсан, сургалтанд хамрагдсан талаар
6. Санхүү, төсөв хөрөнгө, түүний зарцуулалтын талаар
7. Архивын сан бүрдүүлэлтийн талаар
8. Дотоодын болон хөндлөнгийн хяналт шалгалтын талаар
9. Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, ил тод нээлттэй байдлыг хангах талаар
10. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал
11. Мэдээлэл технологийн чиглэлээр
12. Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр
13. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай, аймаг нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд
14. Зохион байгуулсан бусад арга хэмжээ

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2020 ОНЫ 1 ДҮГЭЭР ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2020 оны 6 дугаар сарын 19

Говьсүмбэр аймаг

Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс “Иргэнд суурилсан төрийн бүртгэлийн үнэн ой санамжийг бий болгох, төр, иргэнийг холбосон бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрийн бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг хангах” эрхэм зорилгыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож холбогдох хууль, тогтоомж, тушаал шийдвэрийг даган биелүүлж, Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн яам, УБЕГ, аймгийн Засаг дарга зэрэг дээд байгууллагуудаас ирүүлсэн захирамж хөтөлбөр, тушаал, шийдвэр, чиглэлийг биелүүлэн ажиллаж байна.

Дээд байгууллагын тогтоол, шийдвэр, хууль дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон бусад хуулиуд, Засгийн газрын албан даалгавар, УБЕГазрын даргын тушаал, холбогдох хууль эрх зүйн актууд, дээд газрын тогтоол шийдвэр, чиглэлүүдийг хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн, Улсын бүртгэлийн багц хууль, Төрийн албаны тухай хуулийг албан хаагчид, ард иргэдэд сурталчлан таниулах ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байна.

Удирдлага, зохион байгуулалт, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр /Улсын бүртгэлийн чиглэлээр/:

Тус хэлтэс нь хэлтсийн дарга 1, тасгийн дарга бөгөөд улсын улсын ахлах бүртгэгч 2, хяналтын улсын байцаагч 1, улсын бүртгэгч 6, ахлах нягтлан бодогч 1 нярав бичиг хэргийн ажилтан 1, мэдээлэл технологийн ажилтан 1, архивч 1, гэрээт ажилтан 1 нийт 15 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр ажил үүргээ гүйцэтгэж, иргэний эрхийг төрийн бүртгэлийн үйлчилгээгээр хангах үндсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

2020 онд тус хэлтэс байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө гарган УБЕГ-ын даргаар, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргуулан хэлтсийн даргаар тус тус батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

2020 оны 1 дүгээр хагас жилд хэлтсийн даргын зөвлөлийн болон хамт олны шуурхай хурлыг 15 удаа зохион байгуулж цаг үеийн зарим асуудал болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, судалж танилцах, дагаж мөрдөх үйлчилгээний стандартыг хангаж ажиллах болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх, тайлан мэдээг тогтмол гаргах, ажлын явцыг дүгнэн хэлэлцэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр анхааран ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Аймаг нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд УБЕГ-ын төлөвлөгөө хуваарийн дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийг дүгнэн ажиллаж байна.

Төсвийн орлого төвлөрүүлэх чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр **2,2848,600** төгрөгийн үйлчилгээний хураамж, **1,306,800** төгрөгийн тэмдэгтийн хураамж, эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр **17,688,227** төгрөгийн үйлчилгээний хураамж **1,621,882** төгрөгийн тэмдэгтийн хураамж, **59,199,125** төгрөгийн үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр **12,500** төгрөгийн үйлчилгээний хураамж, **1,709,000** төгрөгийн тэмдэгтийн хураамжийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн.

- ✓ Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хууль тогтоомж зөрчсөн иргэдэд мөнгөн торгууль оногдуулж, торгуулийн мөнгийг улсын төсөвт төвлөрүүлж байна. 2020 онд 6 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар **2,690,000** төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2020 оны 1 дүгээр хагас жилд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Д/д	Бүртгэлийн төрөл	1 дүгээр хагас жилийн байдлаар	
		2019 он	2020 он
1	Төрсний бүртгэл	212	201
2	Гэрлэлт	35	20
3	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл	13	8
4	Гэрлэлт сэргээлт		
5	Үрчлэлт	2	6
6	Эцэг тогтоолт	7	5
7	Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчлөлт	8	1
8	Нас барсны бүртгэл	39	35
9	Иргэний үнэмлэх олголт	557	352
10	Шилжилт хөдөлгөөний бүртгэл	272	223
11	Иргэний шинэчилсэн бүртгэл	128	124
12	25,45 насны сунгалт	192	215
13	Иргэний үнэмлэх дахин олголт	128	117
14	Иргэний үнэмлэхийн лавлагаа	240	321
15	Гэр бүлийн байдлын бүртгэлийн лавлагаа	534	410
НИЙТ		2246	1861

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр

ä/ä	Бүртгэлийн төрөл	1 дүгээр хагас жилийн байдлаар
-----	------------------	--------------------------------

		2019	2020
	Хүлээн авсан мэдүүлэг	2271	1713
1.	Төрөөс хувьчилсан $\text{āāçàð}^{\circ}\text{ì ÷è}^{\circ}\text{ō úðèèéí á¿ðòāýè}$	320	248
2.	Газар эзэмших эрхийн бүртгэл	77	181
3.	Газраас бусад үл хөдлөх хөрөнгийн анхны $\text{á¿ðòāýè āàòāèāāāæóèèèèè}$	13	17
4.	Хооааеаао $\text{òāāèèāāí āāāò āýðýýāýýð}^{\circ}\text{ì ÷è}^{\circ}\text{ā-}^{\circ}\text{ð÷è}^{\circ}\text{āā}^{\circ}\text{ō á¿ðòāýè}$	136	134
5.	Бэлэглэх гэрээ	18	9
6.	Арилжих гэрээ	2	4
7.	$\text{Өâ çàèèāī æèèèāāð}^{\circ}\text{ì ÷è}^{\circ}\text{ā-}^{\circ}\text{ð÷è}^{\circ}\text{āā}^{\circ}\text{ō á¿ðòāýè}$	22	16
8.	Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх		3
9.	$\text{Хàì òðàí}^{\circ}\text{ì ÷è}^{\circ}\text{ā-}^{\circ}\text{ð÷è}^{\circ}\text{āā}^{\circ}\text{ō á¿ðòāýè}$	20	25
10.	Барьцаат зээлийн гэрээ	853	520
11.	$\text{Баðüòāāí ù āýðýý äóóñāāāð áí èā}^{\circ}\text{ō á¿ðòāýè}$	649	478
12.	Түрээсийн гэрээ	2	3
13.	Бүртгэлд өөрчлөлт орсон	24	25
14.	Урьдчилсан тэмдэглэл	20	3
15.	Лавлагаа хуулбар	115	47
16.	$\text{- éè÷èèāýí èè í ðèí ā}$	13,680,284	17,688,227
17.	$\text{Оëñû í òýì äýāèèéí òóðāāì æ}$	67,877	1,621,882
18.	Òàòāàðû í í ðèí ā	278,613,573	59,199,725

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр

Д/д	Бүртгэлийн төрөл	1 дүгээр хагас жилийн байдлаар	
		2019	2020
1.	ХХК	8	14
2.	ТББ	3	6
3.	Хоршоо	1	1
4.	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	1	
5.	Хуулийн этгээдийн салбар		2
6.	Хуулийн этгээдийн өөрчлөлт	36	35

7.	Хураасан тамга тэмдэг	3	6
8.	Тамга тэмдгийн хяналтын хуудас олголт	13	23
9.	НИЙТ	65	87
10.	Тэмдэгтийн хураамжийн дүн (төгрөг)	1,140,000	1,709,000

Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх талаар

- ✓ Албан бичиг хөтлөлтийн хүрээнд ABLE, төрийн байгууллагын цахим шуудангийн www.email.gov.mn системийг тус тус ашиглаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газраас баталсан хуваарийн дагуу сар, улирлын улсын бүртгэлийн үйлчилгээний тоон мэдээ, тайланг гарган нягтлан шалгаж мөн үнэт цаасны зарцуулалт, тайлан тооцоог хугацаанд нь үнэн зөв гарган хүргүүлж, баталгаажуулж хэвшсэн.
- ✓ Албан бичиг эргэлтийн хүрээнд хэлтсийн хэмжээнд нийт 289 албан бичиг ирснийг бүртгэн авч, хариутай 124 албан бичигт хугацаанд нь хариуг нь өгч, нийт 348 албан бичгийг холбогдох газарт явуулаад байна. Иргэн, хуулийн этгээдээс 20 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг нь өгсөн. Хариу хүргүүлээгүй болон хугацаа хоцорсон албан бичиг, өргөдөл гомдол байхгүй болно.
- ✓ Дээд газраас ирүүлсэн албан бичиг, чиглэлийн дагуу холбогдох тайлан мэдээ, судалгааг тухай бүр хугацаанд нь гарган хүргүүлэн ажиллалаа.
- ✓ Тус хэлтсийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, санал хүсэлтийг хүлээн авч түргэн шуурхай, чирэгдэлгүй шийдвэрлэн, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэнд хүргэн ажиллаж байна.

Сургалт зохион байгуулсан, сургалтанд хамрагдсан талаар

Тус хэлтсийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж хуваарь гарган ажиллаж байна. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар авахаас урьдчилан сэргийлэх, Улс болон аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу танхимын сургалтыг зохион байгуулаагүй байна. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудын сургалтыг цар тахлын үеийн онцгой дэглэмийг сахиж хоорондын зай, гар ариутгах биеийн халууныг үзэх зэрэг

шаардлагуудыг бүрэн биелүүлж 1 удаа зохион байгуулсан. Цахимаар зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчид хамрагдсан.

- ✓ Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан удирдах ажилтны цахим сургалт зөвлөгөөнд тус хэлтсийн дарга хамрагдсан.
- ✓ УБЕГ, ХШГ, ХЭУБГ, ИУБГ СТГ-уудаас зохион байгуулсан 8 удаагийн онлайн сургалтанд холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан.
- ✓ Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн цахим сургалтанд итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 12 албан хаагч хамрагдсан.

Санхүү, төсөв хөрөнгө, түүний зарцуулалтын талаар

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2020 оны 1 дүгээр хагас жилд 40 мэдээ мэдээллийг хугацаанд нь оруулсан байна. Оруулбал зохих мэдээллээс оруулаагүй, хугацаа хожимдуулж оруулсан мэдээлэл байхгүй.

2020 онд тус хэлтэс нь 208,778,100 төгрөгийн санхүүжилт авахаас эхний хагас жилийн байдлаар 103,448,100 төгрөгийн санхүүжилтийг авч, холбогдох зардлыг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна.

Хэлтсийн үндсэн хөрөнгө, эд зүйлсийг зүй зохистой ашиглах, батлагдсан төсөв хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, хэмнэж болох зардлыг хэмнэхэд анхаарал тавин ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэглэж байсан иж бүрэн Lucoms компьютер 1 ширхэг, Canon 1300d маркийн зургийн аппарат шинэ 1 ширхэг, аймгийн Засаг даргаас иж бүрэн шинэ Dell компьютер 2 ширхгийг тус тус шийдвэрлүүлэн хүлээн авч албан хаагчдад хуваарилан өгч иргэн, хуулийн этгээдэд илүү түргэн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүллээ.

Ашиглах хугацаа дууссан, эвдрэл гэмтэлтэй, цаашид ашиглах боломжгүй тоног төхөөрөмжийн судалгааг гарган, актлуулах саналыг ТӨБЗГ-т хүргүүлэхээр УБЕГ-т хүргүүлэв.

Хэлтсийн туслах аж ахуй буюу 45 тооны малаас 2 тооны хонийг шаардлагатай албан хаагчид буцалтгүйгээр өгсөн. Тодорхой хугацааны давтамжтайгаар малчныдаа очиж, малаа эргэж тойрох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Архивын сан бүрдүүлэлтийн талаар:

Тус хэлтсийн архивын нэгжид эд хөрөнгийн улсын бүртгэлийн 11985, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 520, Иргэний улсын бүртгэлийн 16371 хувийн хэрэг хадгалагдаж байна. Өдөр тутмын баяжилтыг тогтмол хийж 2020 оны 1 дүгээр хагас жилд 781 хувийн хэргийг архивын сан хөмрөгт нэмж байрлуулж, 3699 эх нотлох баримтыг хувийн хэрэгт нэмж хийж, хувийн хэргийг баяжуулсан байна.

- ✓ Архивын өрөөнүүдийн цэвэрлэгээг батлагдсан хуваарийн дагуу сард 3 удаа хийж, хайрцагны тоос шороо арчиж цэвэрлэн, архивын чийг, дулааныг өдөр бүр хэмжиж графикаар тэмдэглэл хөтлөн, хадгалагдаж байгаа нотлох баримтын аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна.
- ✓ Нийслэл, бусад аймагруу шилжин явсан 139 иргэний хувийн хэрэг, 965 ИУБ маягтыг шилжин явсан аймаг, нийслэлд, өөр аймаг, нийслэлийн хаягтай, тус аймагт улсын бүртгэлд хамрагдсан иргэдийн 19 ИУБ маягтын үндсэн харъяалалтай аймагруу нь тус тус хүргүүллээ.
- ✓ Тус аймагт шилжин ирсэн 14 иргэний хувийн хэрэг, 209 ИУБ маягтыг тус тус шинээр байрлууллаа.
- ✓ Өдөр тутмын үйл ажиллагаанд иргэний 5, эд хөрөнгийн 221 хувийн хэрэг, бүртгэлийн дэвтэр 7-г хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч нараас татан авч үзсэн байна.
- ✓ Архивын аюулгүй байдлыг хангах үүднээс хяналтын камер, агаарын даралт, чийгшил хэмжих зориулалтын багаж, цэнэг бүхий галын хор, хүрз, тармуур, элс зэргийг байрлуулан ажиллаж байна.
- ✓ УБЕГ-ын даргын 2014 оны 814 дугаар тушаалын дагуу архивын ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн зааврын дагуу цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэн ажиллаж байна.

Дотоод болон хөндлөнгийн хяналт шалгалтын талаар:

Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавьж, улсын бүртгэгч нарт мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөг хэлтсийн дарга, хяналтын улсын

байцаагч, улсын ахлах бүртгэгчээс өгч, бүртгэлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Хяналтын улсын байцаагчаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 6, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 5 дүгнэлт тус тус гаргаж, холбогдох засвар, залруулгыг хийгээд байна.

- ✓ Хуулийн хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүй, улсын бүртгэлийн холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн 90 иргэн, 1 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу нийт 2,690,000 төгрөгийн торгууль оногдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн.
- ✓ Улсын бүртгэлийн 1879 нотлох баримтанд нэг бүрчилсэн шалгалтыг хийж хяналт тавьж ажилласан. Үүнээс: иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 708, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 601, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 32, архивын чиглэлээр 538 эх нотлох баримтыг үзэж шалгасан.
- ✓ Шалгалтын явцад 20 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг бүртгэсэн улсын бүртгэгч нараар тухай бүрд нь арилгуулж, зөрчлийн тэмдэглэл үйлдлээ.
- ✓ Гэрчилгээ, үнэт цаасны зарцуулалтад сар бүр тогтмол хяналт тавин ажиллаж, хүчингүй болсон үнэт цаасыг улсын бүртгэлийн хэлтсийн өмч хамгаалах комиссоор шийдвэрлүүлж ажилласан. Үнэт цаас хүчингүй болгосон улсын бүртгэгч нарт дахин алдаа гаргахгүй байх талаар заавар зөвлөмж өгсөн.
- ✓ Хэлтсийн албан хаагчдын үйлчилгээний стандарт, ажлын цаг ашиглалт, хувцаслалт зэргийг сар тутам буюу 6 удаа шалгаж, дүнг хэлтсийн даргад илтгэх хуудсаар танилцуулсан. Гаргасан алдаа зөрчлийг арилгуулж, ахиж алдаа дутагдал гаргахгүй байх талаар заавар зөвлөмж өгсөн.

Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, ил тод нээлттэй байдлыг хангах талаар:

Говьсүмбэр аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсээс үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах талаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

- ✓ Үйлчилгээний ил тод байдлыг хангах зорилгоор хэлтсийн ажлын байр, үйлчилгээний танхим болон 3 суманд мэдээллийн самбар, саналын хайрцаг ажиллуулж, 70541890, 70543056 дугаарын утсуудаар мэдээлэл, зөвлөгөөг тогтмол өгч байна. Эхний хагас жилд 158 иргэн утсаар зөвлөгөө мэдээлэл авсан байна.
- ✓ Тус хэлтсийн угтах үйлчилгээний ажилтан Э.Мөнхнаран нь иргэдэд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр болон төрийн үйлчилгээний цахим машинаас үйлчилгээ авахад нь заавар, зөвлөгөө мэдээлэл өгч, чиглүүлэн ажиллаж байна.
- ✓ Үйлчилгээнд 2019 онд нэвтрүүлсэн “Улсын бүртгэлийн дуудлагын үйлчилгээ”-гээр хүндэтгэх шалтгааны улмаас үйлчилгээний танхимд хүрэлцэн ирэх боломжгүй иргэдийн хүсэлтийн дагуу байгаа газарт нь очиж үйлчилгээ үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулан ажиллаж байна. 2020 оны 1 дүгээр хагас жилд хорих анги, эмнэлэг, гэрээр нь зэрэг газруудад нь очиж улсын бүртгэлийн үйлчилгээгээр 16 иргэний эрхийг ханган ажилласан байна.



Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал:

Байгууллага, ажил үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагааг таньж мэдүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлан ажиллаж байна.

- ✓ www.zaluu.com www.medee.mn www.burtgel.gov.mn www.burtel.gs.gov.mn зэрэг цахим хуудсуудад мэдээ мэдээлэл нийтлүүлж, байгууллага, үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаж байна.
- ✓ www.facebook.com/gb.burtgel фэйсбүүк хуудсаар улсын бүртгэлийн хэлтсээс хууль тогтоомж сурталчлах, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн, нийтэд мэдээлэх боломжтой ажлын талаар болон бусад хийж гүйцэтгэж буй ажил, шинэ мэдээ мэдээллийг тогтмол оруулан, иргэдийн сонирхсон асуултад хариулан, уг хуудсыг хөтлөн ажиллуулж байна.

Мэдээлэл, технологийн чиглэлээр:

УБЕГ-ын МТГазраас ирүүлсэн заавар зөвлөмж, чиглэлийн дагуу ажил үйлчилгээг хэрэгжүүлж, хамтарч ажиллаж, мэдээлэл, програм хангамж, сүлжээний аюулгүй байдлыг хангаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг шаардлагатай тохиолдолд хийж, сервэрийн аюулгүй ажиллагаа, өдөр тутмын үзлэг үйлчилгээг хийж гүйцэтгэн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

- ✓ УБЕГ-аас 1 ширхэг зургийн аппарат, 1 ширхэг иж бүрэн хуучин компьютер, аймгийн Засаг даргаас 2 ширхэг иж бүрэн шинэ компьютер зэргийг шийдвэрлүүлэн албан хаагчдад шилжүүлж, ажиллах нөхцлийг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг илүү хурдан шуурхай хүргэх боломж нөхцлийг бүрдүүллээ.
- ✓ Байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудсын ажиллагааг тогтворжуулж цаг үе, үйл явдлын мэдээг тухай бүрт нь байршуулж иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх ажлыг хийж гүйцэтгэж байна.
- ✓ Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрт нь бүртгэж аван холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна.
- ✓ Хэлтсийн албан хэрэгцээний 6 ширхэг компьютерийг форматалж, вирус, хортой кодыг устган цэвэрлэлээ. Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн гэмтлийг засч хэвийн ажиллагаанд орууллаа.

Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах

чиглэлээр

- ✓ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар 3 албан хаагчид зэрэг дэв шинээр, 1 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон.
- ✓ Хэлтсийн дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэр гарган 4 албан хаагчийн цалингийн шатлалыг нэмлээ.
- ✓ Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн үйлчилгээний 3 албан хаагчид төрийн алба хаасны нэмэгдлийг шинээр, ажилласан жил нь дараагийн 5 жилрүү орсон 2 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг нэмэгдүүлэн зохих журмын дагуу олгож эхлээд байна.
- ✓ Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан ур чадварын нэмэгдэл олгон ажиллаж байна.
- ✓ УБЕГ-ын даргын 2020 оны б/99 тоот тушаалаар тус хэлтсийн дарга Ө.Манжил 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс жинхлэн томилогдсон.
- ✓ Хэлтсийн дарга Ө.Манжил Удирдлагын академийн ахлах түшмэлийн багц сургалтанд үнэ төлбөргүй хамрагдаж, сертификатаа гардан авсан.
- ✓ УБЕГ-аас 1 ширхэг зургийн аппарат, 1 ширхэг иж бүрэн хуучин компьютер, аймгийн Засаг даргаас 2 ширхэг иж бүрэн шинэ компьютер зэргийг шийдвэрлүүлэн албан хаагчдад шилжүүлж, ажиллах нөхцлийг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг илүү хурдан шуурхай хүргэх боломж нөхцлийг бүрдүүллээ.
- ✓ 1 албан хаагч УБЕГ-ын даргын цалинтай чөлөөгөөр Улаанбаатар хотод эрх зүйч мэргэжлээр суралцаж байна.
- ✓ Албан хаагчдын хүүхэдтэйгээ ойр байх, хүүхэддээ тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэх үүднээс тус хэлтсийн даргын 2019 оны а/19 тоот тушаалын дагуу албан хаагчийн 16 хүртэлх насны хүүхдүүдийнх нь төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгон ажиллаж байна.
- ✓ Аймгийн засаг даргын тамгын газрын өмчлөлийн 1 өрөө 50м² байрыг хэлтсийн дарга зөвхөн хэрэглээнийхээ зардлыг төлөн ашиглаж, орон сууцны асуудлыг шийдвэрлүүлсэн.

- ✓ Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу давхардсан тоогоор 9 албан хаагчид 22 хоногийн цалинтай чөлөө олгосон.
- ✓ Шинээр хүүхэдтэй болсон 2 албан хаагчид хэлтсийн мал аж ахуйгаас 2 тооны хонийг буцалтгүй тусламж болгон олгосон.
- ✓ Тус хэлтсийн угтах үйлчилгээний ажилтан хөгжлийн бэрхшээлтэй иргэн Э.Мөнхнаранг 7 хоногт 36 цаг ажиллуулж, цалинг бүтэн ажилласнаар тооцон олгож байна.
- ✓ 6 сар хүрээгүй нярай хүүхэдтэй ажилтан болох улсын бүртгэгч Л.Пүрэвжаргалд өдөрт 2 цагийн цалинтай чөлөө олгон, цалинг бүтэн ажилласнаар тооцон олгож байна.
- ✓ Ковид 19 вирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд албан хаагчдад 105.700 төгрөгийн үнэ бүхий 185 ширхэг амны хаалт, 88350 төгрөгийн үнэ бүхий 24 ширхэг гар ариутгагчийг олгож, албан хаагчдын өрөө тасалгааг 1 удаа бүрэн ариутгуулсан.
- ✓ Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан албан хаагчдын 28 хүүхдэд 420.000 төгрөгийн бэлэгийг олгосон.
- ✓ Угтах үйлчилгээний ажилтан Э.Мөнхнаранд 108.000 төгрөгийн үнэ бүхий цагаан сарын тавагийн идээг бэлтгэн өгсөн.
- ✓ Тус хэлтсийн өндөр настан 3 ахмадад цагаан сарын бэлтгэлд нь зориулж 80.000 төгрөгийг хэлтсээс, УБЕГ-аас 50.000 нийт 130.000 төгрөгийг тус тус олгосон.
- ✓ Албан хаагчдад 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангийн үнэлгээ, үр дүнг харгалзан 8 албан хаагчид 1,958,700 төгрөгийн урамшуулал олгосон.
- ✓ Аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулсан.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Аймаг нийслэл сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УБЕГ-ын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байгаа бөгөөд дараах томоохон хэмжээний ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Овог нэр, төрсөн он, сар өдөр ижил бөгөөд тус аймгийн хаягтай 26 иргэний мэдээллийг тулган шалгаж 12 иргэн нь өөр хүмүүс болохыг, 7 иргэн нь 2 регистрийн дугаар бүхий иргэд болохыг тогтоож, 7 иргэний регистрийн дугаарыг хүчингүй болгуулахаар хяналтын улсын байцаагчид шилжүүлсэн.
- ✓ Тус аймгаас шилжин яваад, очсон газартаа бүртгүүлээгүй 34 иргэний мэдээллийг хүлээн авч, 15 иргэний хаягийн зөрчлийг арилгууллаа.
- ✓ Говьсүмбэр аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 24:00 цагаар тасалбар болгон түр зогсоолоо.
- ✓ Монгол Улсын Их хурлын ээлжит сонгуулийн санал авах байр, хэсгийн төвийг зарлах тухай Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолыг хуулийн хугацаанд хүлээн авч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн., ИТХТ-ийн тогтоолын дагуу байгуулагдсан сонгуулийн хэсгийн 9 төвд эрх олгогдсон улсын бүртгэгч нарын бүртгэн оруулсан 3326 хаягийг нягтлан шалгаж баталгаажуулж ажиллалаа.
- ✓ Говьсүмбэр аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 6 дугаар тойргийн 6.1-ээс 6.9 дүгээр хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, Говьсүмбэр аймгийн 3 сумын сонгуулийн 9 хэсгийн хороонд хүлээлгэн өглөө.
- ✓ Сонгогчийн бүртгэлийн тоног төхөөрөмжийг тус хэлтсийн дарга Ө.Манжил, хяналтын улсын байцаагч З.Баяндугар, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга Э.Ууганбат, мэдээллийн технологийн ажилтан Ч.Хишигбаатар, тагнуулийн хэлтсийн ажилтан Ч.Мөнх-Эрдэнэ, цагдаагийн

хэлтсийн ажилтан 2 албан хаагчдын хамтаар авчирч цагдаагийн хэлтсийн байранд лацдан байрлуулсан.

- ✓ Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах лавлагааг 2020 оны 06 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд хэвлэлээ. Тус аймаг дахь 9 хэсгээс нийт шилжин явсан 54, хэсгүүдэд шилжин ирсэн 50, түр хасав тэмдэглэгээг сэргээсэн 3, иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлтөөр нэмсэн 1, нас барсны бүртгэлээр хасагдсан 4, нийт 112 лавлагааг хэвлэлээ. Хэвлэсэн лавлагааг хяналтын улсын байцаагч шалгаж, хэлтсийн дарга баталгаажуулж тус тус тэмдэг дарж, гарын үсэг зурсан. Хэвлэсэн лавлагааг улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад хүлээлгэн өгсөн.
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулиар тус аймагт ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад хууль эрх зүй, программ хангамж, тоног төхөөрөмжийн сургалтыг 2020 оны 6 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулж, сонгогчийн нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах лавлагааг программд шивж оруулан, нийт 11039 сонгогчийн мэдээлэл бүхий нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэлээ.
- ✓ Аймаг нийслэл сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн санал авах байр, хэсгийн төвийг зарлах тухай Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолыг хуулийн хугацаанд хүлээн авч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Зохион байгуулсан бусад арга хэмжээний талаар:

- ✓ Хэлтсийн аж ахуйн өрөөнд тавиур байрлуулан тохижуулж, байгууллагын архив болгосон бөгөөд байгууллагын архивыг улсын бүртгэлийн төрөлжсөн архиваас салгаж, нярав бичиг хэргийн ажилтан Х.Мягмаржаргалд хариуцуулаад байна.



- ✓ Албан хаагчид өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан эрэгтэйчүүд пиджак, жилет, эмэгтэйчүүд ажлын платье-тэй болж, 1 өнгийн хувцсаар жигдрээд байна.



- ✓ Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ХАСХОМ гаргах үүрэг бүхий 11 албан хаагчийн 2019 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүллээ.
- ✓ Албан хаагчдаар болон Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах төрийн албан хаагчдаар нууцын баталгааг шинэчлэн гаргууллаа.

- ✓ Аймгийн ЗДТГ-ын нэг цэгийн үйлчилгээний танхимд гэрчилгээ, үнэмлэх ёслолтой гардуулах, иргэд дурсгалын зураг авхуулах самбарыг хийж байрлууллаа.



- ✓ Үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан өөрийн хариуцсан талбайд 11 ширхэг мод бутыг тарьж суулгалаа. Мөн өмнө тарьсан мод бутгаа арчилж, усалгааг нь хуваарь гарган хийж гүйцэтгэж байна.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС